

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2014 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2014 оны 02 -р сарын 26 -ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт				Хариуцах эзэн	Хүрэх үр дүн	Оноо
			Хүн хүч	Хөрөнгө санхүү	Хугацаа	Гүйцэтгэлийн үзүүлэлт			
НЭГ. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ САНАЛ, САНААЧИЛГА									
1	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлтыг нэмэгдүүлэх.	1.1. Цагдаагийн байгууллагын бүтэц шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулж, Авлигаас урьдчилан сэргийлэх орон тооны бус салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, мөрдүүлэх.	Хүн/өдөр		1-р улиралд	<ul style="list-style-type: none"> Зөвлөлийн гишүүн, байгууллагын дарга тус бүр авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажил санаачлан хийсэн байх. 	Дотоод хяналт-Аюулгүй байдлын газар	Удирдлагын манлайлал дээшилж иргэдийн дунд цагдаагийн байгууллагын удирдах бие бүрэлдэхүүнд итгэх итгэл нэмэгдэнэ.	
		1.2. Цагдаагийн ерөнхий газрын дарга авлигыг үл тэвчих, ёс зүйтэй байх, шударга ёсыг эрхэмлэн ажиллах талаар үүрэг, чиглэл гаргах, хэвлэлд ярилцлага өгөх.	Хүн/өдөр		1-р улиралд	<ul style="list-style-type: none"> Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсанд байршуулж иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэсэн байх Нийт бие бүрэлдэхүүндээ хүргэсэн байх. 	ЦЕГ-ын даргын ажлын алба, Дотоод хяналт-Аюулгүй байдлын газар, Хэвлэл мэдээллийн төв		
		1.3. Авлигын эсрэг арга хэмжээнд зориулсан санхүүжилтийг шийдвэрлүүлэх, 2015 оны төсөвт тусгуулах.	Хүн/өдөр		Жилд	<ul style="list-style-type: none"> Авлигын эсрэг арга хэмжээнд зориулсан хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн байдал. 	Санхүү, хангамжийн газар, Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс		
		1.4. Цагдаагийн газар, хэлтсүүдийг цахим хуудас, фэйсбүүк, твиттертэй болгоход шаардагдах зардал, төлбөрийн хураамжийн эх үүсвэрийг нэгдсэн журмаар шийдвэрлүүлэх.	Хүн/өдөр		Жилд	<ul style="list-style-type: none"> Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлт хангагдана. 	Санхүү, хангамжийн газар, Хэвлэл мэдээллийн төв		
		1.5. Авлига, хүнд суртал болон ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй цагдаагийн байгууллагын ажлын байр, албан тушаалыг тодорхойлох судалгааны ажлыг хийлгэх. Түүний дагуу урьдчилан сэргийлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах.	Хүн/өдөр		Жилд	<ul style="list-style-type: none"> Удирдах албан тушаалтнуудын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, хүчин чармайлт, тэдний үлгэр жишээ байдал. 	Дотоод хяналт-Аюулгүй байдлын газар		

		1.6. Алба хаагчдын дунд авлигаас урьдчилан сэргийлэх илтгэл, нийтлэлийн уралдаан зарлаж, шалгарсан илтгэл, нийтлэлийг цахим хуудсанд байршуулах, цагдаа сэтгүүлд нийтлүүлэх хэлбэрээр нийтэд сурталчлах, түүнээс гарсан санал, санаачлагыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх.	Хүн/өдөр		Жилд	<ul style="list-style-type: none"> Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ /шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг, зөвлөмж өгөх г.м/-ний үр дүн. 	Хэвлэл мэдээллийн төв		
		1.7. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх журам боловсруулах.	Хүн/өдөр		2-р улиралд	<ul style="list-style-type: none"> Журам батлагдсан байх. 	Дотоод хяналт-Аюулгүй байдлын газар, Хуулийн хэлтэс		
ХОЁР. ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ									
2	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах	2.1. Авлигын тухай ойлголт, хор уршиг, авлигыг үл тэвчих, шударга байх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дунд сургуулийн сурагчдын дунд /8-12-р анги/ гар зургийн уралдаан зохион байгуулах.			Жилд	<ul style="list-style-type: none"> Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээл-лийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал г.м/ 	Хэвлэл мэдээллийн төв, Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс	Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа сайжирна.	
		2.2. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль, түүнд нийцүүлэн гаргасан журам, зааврыг эмхтгэн хэвлүүлж, алба хаагчдад сурталчилах.	багаар		Жилд	<ul style="list-style-type: none"> Гарын авлга товхимол хэвлэгдэж хүргэгдсэн байх 	Дотоод хяналт-Аюулгүй байдлын газар		
3	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох	3.1. Цагдаагийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Цагдаагийн байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх журмын төслүүдийг алба хаагчдад танилцуулах, хэлэлцүүлэх, санал солилцох.	Хүн/өдөр		Байнга	<ul style="list-style-type: none"> Дүрмийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж нэгжид хүргүүлсэн байх Хэрэгжилтийг тухай бүр тооцож ажилласан байх 	Хуулийн хэлтэс	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилт хангагдана.	
		3.2. Нийтээр дагаж мөрдөх актын төсөлд санал авах.	багаар		Тухай бүр	<ul style="list-style-type: none"> Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ шинээр боловсруулан шийдвэрийн төслийг олон нийтэд байршуулан санал авсан байдал. 	Хуулийн хэлтэс		

		3.3. Шинээр боловсруулагдаж батлагдсан бодлогын баримт бичиг, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг цахим хуудсанд байршуулан олон нийтэд танилцуулах.	Хүн/өдөр		Тухай бүр	<ul style="list-style-type: none"> • Боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулсан байдал 	Хууль тогтоомжийн хэрэгжилт, дотоод ажлын хэлтэс		
4	<i>Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах</i>	4.1. Дотоод хяналт- Аюулгүй байдлын газраас төлөвлөгөөт бус шалгалтыг хийж, хийсэн ажил болон шийдвэрийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх.	багаар		тухай бүр	<ul style="list-style-type: none"> • Шалгалт хийсэн байх • Хийсэн ажил, шалгалтын шийдвэрийн талаар нийтэд мэдээлсэн байх /нууцаас бусад асуудлыг/ 	Дотоод хяналт- Аюулгүй байдлын газар, Хэвлэл, мэдээллийн төв	Дотоод хяналт шалгалт сайжирч, байгууллагын үйл ажиллагаа шуурхай болж, алба хаагчдын шударга байдал дээшилнэ.	
		4.2. Цагдаагийн байгууллагуудад санхүү, аж ахуйн чиглэлээр шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах.	Хүн/өдөр		тухай бүр	<ul style="list-style-type: none"> • Шалгалт хийгдсэн байх • Дутагдлыг засуулсан байх 	Дотоод хяналт- Аюулгүй байдлын газар		
5	<i>Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах</i>	5.1 Цагдаагийн байгууллагаас тусгай зөвшөөрөл олгоход бүрдүүлэх материал, хаана, хэнд, хэрхэн хандах зэргийг олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр цахим хуудсанд байршуулах.	багаар		тухай бүр	<ul style="list-style-type: none"> • Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрх-лэх зөвшөөрөл/-ийн жагсаалт, түүнийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмын нээлттэй байдал 	Хууль тогтоомжийн хэрэгжилт, дотоод ажлын хэлтэс	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилт хангагдана.	
6	<i>Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох</i>	6.1. Алба хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг батлаж, үр дүнгийн гэрээг байгуулах.	Хүн/өдөр		Тухай бүр	<ul style="list-style-type: none"> • Алба хаагчдын ажлын байрны тодорхойлолт батлагдсан, үр дүнгийн гэрээг байгуулагдсан байх. 	Хууль тогтоомжийн хэрэгжилт, дотоод ажлын хэлтэс	Албан хаагчийн ажил үүргийн хуваарь тодорхой болж ажлын бүтээмж сайжирна.	
		6.2. Алба хаагчдын ажил, үр дүнг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг баримтлан үнэлж, дүгнэх.	Хүн/өдөр		Жилд	<ul style="list-style-type: none"> • Шалгуур үзүүлэлтийг баримтлан ажил, үр дүнгийн гэрээг дүгнэсэн байх 	Хууль тогтоомжийн хэрэгжилт, дотоод ажлын хэлтэс, Төв, орон нутгийн цагдаагин газар, хэлтэс		
7	<i>Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх</i>	7.1. Цагдаагийн байгууллагын бүтэц шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулж, эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-уудыг шинэчлэн томилуулж, ажлын байрны тодорхойлолтыг батлуулах. ЭБАТ-ын нэмэгдлийг шийдвэрлүүлэх.	Хүн/өдөр		Жилд	<ul style="list-style-type: none"> • Эрх бүхий албан тушаалтныг томилсон байдал • Гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгасан байдал • Хувь хүний нууцтай холбогдох мэдээллийн хадгалалт, хамгаалалтын байдал /ба- 	Дотоод хяналт- Аюулгүй байдлын газар, Санхүү, хангамжийн газар	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах үйл ажиллагаа сайжирна.	

	<i>газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх</i>					талгаа/ • Эрх бүхий албан тушаалтны ажлын үр дүнгийн байдал • Байгууллагын хэмжээнд сургалт зохион байгуулсан байх • Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байдал	Дотоод хяналт-Аюулгүй байдлын газар		
		7.2. Төв, орон нутгийн цагдаагийн газар хэлтсийн салбар эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-уудад сургалт зохион байгуулах.	багаар		Жилд				
8	<i>Иргэдийн өргөдөл /санал, мэдээгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах</i>	8.1. Иргэдээс гаргасан, ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, санал, хүсэлт бүрийг хүлээн авч, бүртгэн, мэдээллийн санд оруулж, шийдвэрлэлтийг удирдлагын зүгээс байнга хянаж, хүний зөрчигдсэн эрх, эрх чөлөөг хангаж ажиллах.	Багаар		жилдээ	• Гомдол, мэдээлэл бүрийг хүлээн авч, бүртгэх • Мэдээллийн санд оруулсан байх • Удирдлагын зүгээс байнга хянаж байх • Иргэдийн зөрчигдсэн эрх хангагдсан байх	Хууль тогтоомжийн хэрэгжилт, дотоод ажлын хэлтэс, Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс		
		8.2. Алба хаагчдаас авлига, хүнд сурталтай холбоотой мэдээлэл хүлээн авах 126 дугаарын утсаар мэдээлэл хүлээн авах, мэдээллийн дагуу шалгах үйл ажиллагааг тогтмолжуулах.	Хүн/өдөр		Тухай бүр	• 126 дугаарын утсыг жижүүрт байрлуулсан байх • Шалгалт хийсэн байх	Дотоод хяналт-Аюулгүй байдлын газар		
		8.3. Алба хаагчийн хууль бус үйлдэл, авлига, хүнд суртлын талаарх тусгай дугаарын утас, саналын хайрцаг, дэвтрээр ирсэн гомдол, мэдээллийн мөрөөр шалгалт хийж, шийдвэрлэж байх.	Хүн/өдөр		Тухай бүр	• Гомдол, мэдээллийн мөрөөр тодорхой ажил зохиосон байх • Мэдээлэгч ба мэдээллийн нууцлалыг хангах талаар баталгаа авсан байх • Задруулсан тохиолдолд хариуцлага хүлээдэг тогтолцоонд шилжсэн байх	Дотоод хяналт-Аюулгүй байдлын газар, Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс		
9	<i>Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах</i>	9.1. Алба хаагчдаас авлигын сэжигтэй тохиолдол болон авлига өгөхөөр оролдсон, санал болгосон, зуучилсан талаарх мэдээллийг тухай бүр харилцан солилцож, хамтран ажиллаж мэдээллийг харъяаллын дагуу шилжүүлэн шийдвэрлүүлж ажиллах	Хүн/өдөр		тухай бүр	• Мэдээллийг тухай бүр харилцан солилцож хамтран ажилласан байх • Мэдээллийг харъяаллын дагуу шилжүүлж шийдвэрлүүлсэн байх	Дотоод хяналт-Аюулгүй байдлын газар, Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс	Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа сайжирна.	
		9.2. Алба хаагч бүр авлигын сэжигтэй тохиолдол болон авлига өгөхөөр оролдсон, санал болгосон тохиолдолд холбогдох албан тушаалтан, байгууллагад заавал мэдээлдэг байх, Иргэдээс авлига өгөхийг санал болгосон, өгөхөөр завдсан тухай илтгэсэн үнэнч, шударга алба хаагчийг урамшуулах, шагнах, бие бүрэлдэхүүний үнэнч шударга байр суурь, итгэл үнэмшил төлөвшүүлэхэд ашиглах.	Хүн/өдөр		тухай бүр	• Нэн даруй мэдэгдсэн байх • Урамшуулсан байх	Дотоод хяналт-Аюулгүй байдлын газар, Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс		
		9.3 Удирдах албан хаагчдын авлигын	багаар		Жилдээ	• Нэргүй санал асуулга авах	Дотоод хяналт-		

		хандлагын талаар нийт бүрэлдэхүүнээс болон орон нутгийн хууль хяналтын байгууллага, иргэдээс санал асуулга авч, тандалт хийж, дүгнэлт гаргаж, дүнг удирдлагад танилцуулсан байх				<ul style="list-style-type: none"> Санал асуулгын дүнд тулгуурлан цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх 	Аюулгүй байдлын газар		
		9.4. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012.04.25-ны өдрийн 05 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, анхаарах асуудлаар нийт алба хаагчдын дунд сургалт зохион байгуулах.	багаар		Жилдээ	<ul style="list-style-type: none"> Сургалт зохион байгуулсан байх. 	Сургалт дадлагын төв		
10	<i>Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар Авлигатай тэмцэх газарт мэдээлэх</i>	10.1. Алба хаагчдын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг нэгтгэн, хуулийн хугацаанд нь Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх.	Хүн/өдөр		тухай бүр	<ul style="list-style-type: none"> Хөрөнгө орлогын мэдүүлгийг хүргүүлсэн байх 	Дотоод хяналт-Аюулгүй байдлын газар	Авлигын эсрэг хуулийн хэрэгжилт хангагдана.	
		10.2. Алба хаагчдын мэдүүлсэн хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэгт хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах.	Хүн/өдөр		тухай бүр	<ul style="list-style-type: none"> Зөрчил арилсан байх 	Дотоод хяналт-Аюулгүй байдлын газар		
		10.3. Шинээр томилогдсон, их хэмжээний өөрчлөлт орсон алба хаагчдаас тухай бүр мэдүүлгийг гаргуулан авч цахим санд оруулах, түүнд хяналт тавих.	Хүн/өдөр		тухай бүр	<ul style="list-style-type: none"> Мэдээлэл санд орсон байх. 	Дотоод хяналт-Аюулгүй байдлын газар		
ГУРАВ. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ									
11	<i>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах</i>	11.1. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Цагдаагийн байгууллагын цахим хуудсанд хариуцан оруулах мэдээллийн бүтэц, товыг боловсруулж мөрдүүлэх.	багаар		тухай бүр	<ul style="list-style-type: none"> Цахим хуудасны мэдээллийн сангийн тасралтгүй үйл ажиллагаа хангагдсан байх. 			
12	<i>Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх</i>	12.1. Тухайн жилд төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх.	Хүн/өдөр		2-р улиралд	<ul style="list-style-type: none"> Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг цахим хуудсанд байршуулсан байх Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тавьсан байх 	Санхүү, хангамжийн газар	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилт хангагдана.	
		12.2. Тухайн жилд төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний явц, үр дүнгийн талаар ЦЕГ-ын даргын зөвлөлд мэдээлэл хийх, салбар зөвлөлд ирүүлэх. Цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх.	Хүн/өдөр		Улирал бүр	<ul style="list-style-type: none"> Төсөл, арга хэмжээний явц, үр дүнгийн талаар мэдээлэл бэлтгэсэн байх Мэдээллийг ЦЕГ-ын даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байх Салбар зөвлөлд ирүүлсэн байх 	Санхүү, хангамжийн газар		
13	<i>Төрийн болон орон нутгийн</i>	13.1. Бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах зарыг	багаар		тухай бүр	<ul style="list-style-type: none"> Зарыг цахим хуудсанд байршуулсан байх 	Санхүү, хангамжийн газар		

	<i>өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах</i>	цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх.				<ul style="list-style-type: none"> • Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд түгээсэн байх 		
		13.2. Сонгон шалгаруулалт, тендерийн үнэлгээний хороонд сонирхлын зөрчилгүй хөндлөнгийн төлөөлөл /комисс, оролцогч этгээдүүдийн талд хамааралгүй/-ийг оролцуулсан байх.	Хүн/өдөр		тухай бүр	<ul style="list-style-type: none"> • Хөндлөнгийн төлөөллийг заавал оролцуулсан байх 	Санхүү, хангамжийн газар	
14	<i>Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах</i>	14.1. Ажилд авах, албан дэвшүүлэх, гадаад, дотоодод суралцуулах, шагнах, урамшуулах зэрэг сонгон шалгаруулах үйл ажиллагаа, журмуудыг нийтэд ил тод байлгах, оролцогч бүрийг ижил тэгш мэдээллээр хангаж шударгаар шийдвэрлэх.	Хүн/өдөр		Тухай бүр	<ul style="list-style-type: none"> • Хүний нөөцийг ил тод байдлаар шударгаар бүрдүүлж, мэргэжлийн чадварлаг алба хаагч нар бүрэлдүүлсэн байх 	Хүний нөөц, сургалтын хэлтэс	

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР